*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 20 23 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
С.ШИНЭБАЯРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Нэг. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО** | | | | | | | |
| **Зорилт 1.1 "Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. "** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.2.** Харилцаа холбооны салбарт шинээр болон шинэчлэн боловсруулсан стандарт, норм дүрмийн төсөлд санал өгөх | Стандарт, норм, дүрмийн төсөлд өгсөн саналын тоо | 0 | 4 | 1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт мөрдөгдөж буй тайлбар толь, нэр томьёоны үндэсний стандартуудад хийгдсэн үзлэгээр "Шуудан холбоо.Нэр томьёо" MNS 0515:2022, Шуудангийн дугтуй. "Нэр томьёо. Ангилал. Хэмжилт" MNS 3963:2014 стандартуудыг шинэчлэхэд нэр томъёотой холбоотой 4 санал боловсруулж ажлын хэсэгт хүргүүлэв.<br>2. ХХЗХ-ны 2024 оны А/272 тоот тушаалаар Шуудан холбооны стандартуудын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж Шуудан хэрэглэгдхүүн, 1-р хэсэг, Шуудангийн тэмдэг MNS 5380-1:2004, Шуудан хэрэглэгдхүүн, 2-р хэсэг, Шуудангийн маягт MNS 5380-2:2004, Шуудангийн аюулгүй байдал MNS 5539:2019 стандартуудад үзлэг хийж, батлагдсан маягтын дагуу шинэчлэх саналаа боловсруулан narantsetseg@crc.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. | 2024.01.02 - 2024.04.10<br>2024.10.06 - 2024.11.25 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.1.3.** | Шинээр боловсруулж | 0 | 5 | 1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5, МУ-ын Засгийн газрын 2023 оны | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5, МУ-ын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор батласан "Хяналтын байцаагчийн эрх олгох цуцлах журам"-ын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлэх алба хаагчдад улсын байцаагчийн эрх олгох, цуцлах үнэмлэх тэмдэг олгуулах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах | батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | | | 06 дугаар тогтоолоор баталсан "Хяналтын байцаагчийн эрх олгох цуцлах журам"-ын дагуу сайдын 2024 оны Б/05 дугаар тушаалаар 1 улсын байцаагчийн эрхийг цуцлах, Б/06 дугаар тушаалаар 1 улсын ахлах байцаагчид эрхийг олгох, Б/07 дугаар тушаалаар 2 улсын байцаагчид эрх олгох, Б/11 дугаар тушаалаар 3 улсын байцаагчид эрхийг олгох, Б/16 дугаар тушаалаар 1 улсын байцаагчийн эрхийг цуцлах, Б/28 дугаар тушаалаар Салбарын улсын ерөнхий байцаагчийн эрх цуцлах, Б/31 дугаар тушаалаар Салбарын улсын ерөнхий байцаагчийн эрх олгох, нийт 7-н тушаал гаргаж, шийдвэрүүдийг албажуулсан. Мөн Харилцаа холбооны зохицуулах хороо, Жанжин штабаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 7-н албан тушаалтанд Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг олгосон. | 2024.02.02 - 2024.12.30 | |
| 3 | **Арга хэмжээ 1.1.4.** Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгжийн дарга, улсын байцаагчдын үнэмлэх, тэмдэг хэвлүүлэх, зардлын тооцоог боловсруулж Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэх | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 2 | 1. Улсын /ахлах/ байцаагчдын 6 ширхэг тэмдгийг 320.000 төгрөгөөр Шүрэн тамга ХХК-иар хийлгэн бүртгэл хөтлөн олгосон.<br>2. Монгол Улсын Их хурлын сонгуулийн үр дүнгээр байгууллагдсан Засгийн газрын бүтцээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болсон тул Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын ахлах байцаагчийн 4, улсын байцаагчийн 22 нийт 26 ширхэг тэмдэгний резинийг 780.000 төгрөгөөр хийлгэсэн.<br>3. Говь-Алтай аймгийн Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн тэмдэгийг 120.000 төгрөгөөр хийлгэсэн. | 2024.03.02 - 2024.12.30 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 1.1.5.** Салбарын хяналт шалгалтад хамаарах объектын жагсаалтыг боловсруулж, салбарын сайдаар батлуулах | Шинээр боловсруулж батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | 0 | 1 | 1. Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолын дагуу Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах обьектын жагсаалт батлах тухай Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 дугаар тушаал батлуулсан. | 2024.01.02 - 2024.01.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Арга хэмжээ 1.1.6.** "Шуудангийн үйлчилгээ эрхлэгч этгээдийг шалгах хяналтын хуудас"-ыг шинээр батлагдсан хууль, журам, стандартын дагуу шинэчлэн боловсруулж батлуулах | Шинээр боловсруулж батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | 0 | 1 | Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, хяналтын хуудсыг боловсруулж, оролцогч талуудаас санал авч тусган, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/153 дугаар тушаалаар батлуулсан. | 2024.11.02 - 2024.12.10 | 100 |
| 6 | **Арга хэмжээ 1.1.7.** Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт, 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | Салбарын хяналтын 15 улсын ахлах, байцаагч, улсын байцаагч нийт нийт 1151 объектод эрсдэлийн ангиллын үнэлгээ хийж 2025 оны төлөвлөгөөт шалгалт хийх их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 171 объектын жагсаалтыг Засгийн газрын Хяналт, үнэлгээний үндэсний хороонд Төрийн нарийн бичгийн даргын 2024.10.30-ны өдрийн 01/695 дугаартай албан бичгээр хүргүүлсэн нь Засгийн газрын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралаар батлагдсан. | 2024.10.02 - 2024.10.31 | 100 |
| 7 | **Арга хэмжээ 1.1.8.** Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 1 | 1. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 24 улсын (ахлах) байцаагчдыг хамруулан цахим хөгжил, харилцаа холбооны салбарын бодлого, чиглэл, хууль эрх зүй, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах нэгдсэн арга хэмжээг 2024 оны 04 дугаар сарын 03,04,05-ний өдрүүдэд Төрийн албан хаагчийн шударга байдлыг нэмэгдүүлэх, хувь хүний ёс зүйн манлайллыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох соён гэгээрүүлэх сэдвийн хүрээнд зохион байгуулсан.<br>2. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид болон сайтуудын дунд зохион байгуулсан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой сургалтад Ахлах шинжээч Б.Бүрэнжаргалтай хамт оролцож "Монгол Улсын Их хурлын 2024 ээлжит сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар | 2024.03.15 - 2024.04.15<br>2024.04.20 - 2024.05.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах арга хэмжээ, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр мэдээлэл хийж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажилласан.<br>3. Монгол шуудан ХК-д хийгдэх төлөвлөгөөт хяналт шалгалтын үед анхаарах асуудлын талаар 16-н Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын /ахлах/ байцаагчдад зөвлөмж өгч ажилласан | 2024.08.20<br>-<br>2024.11.10 | |
| **Хоёр. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ**<br>6.2. Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангуулах | | | | | | | |
| **Зорилт 2.1. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг ухаалгаар удирдана.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1.2.**<br>Хяналт шалгалтын объектуудад эрсдлийн үнэлгээ хийх. | Хяналт шалгалтын нийт объектод эрсдлийн үнэлгээнд хамрагдсан объектын эзлэх хувь | 8 | 9 | Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал зааварчилгааны дагуу Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр 105 обьектод эрсдэлийн үнэлгээ хийсэн нь нийт хяналт шалгалтын объектод эзлэх хувь 9.08 байсан. Эрсдлийн үнэлгээгээр Их эрсдэлтэй-6, Дунд эрсдалтэй-17, Бага эрсдэлтэй 82 үнэлэгдсэн. | 2024.10.09<br>-<br>2024.10.15 | 100 |
| **Зорилт 2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.2.1.**<br>Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийн, их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах объектуудад төлөвлөгөөт болон | Хууль сахин мөрдөлт /хувь/ | 75.68 | 78 | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 07 дугаар сарын 08-ны 09-00/10, 09-00/11, 2024 оны 07 дугаар сарын 09-ний 09-00/12, 09-00/13, 2024 оны дугаар сарын өдрийн 09-00/13 дугаартай удирдамжийн дагуу Мэдээлэл хобооны сүлжээ ТӨХК, Монголын цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХК, Радио телевизийн үндэсний сүлжээ УӨҮГ, Юнивишн ХХК-иудийн төв, 6 аймгийн | 2024.03.20<br>-<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. | Эрсдэл үүсэх магадлалын бууралт /хувь/ | 30.2 | 28.3 | салбар нэгж зэрэг 22 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын танилцуулга гарган, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 129 заалт бүхий 22 улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан. Хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлт 78.4 хувьтай, Эрсдэл үүсэх магадлал 26.5 хувьтай үнэлэгдлээ. | | |
| 3 | **Арга хэмжээ 2.2.2.** Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Зөрчил арилгуулалт /хувь/ | 74 | 79 | 1. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Барилга,хот байгуулалтын яамны хамтарсан 09-00/01,02-00/14 дугаартай урьдчлан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр батлуулан Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт баригдаж буй Мэдээлэл холбооны Дархан дэд төвийн барилгад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор БИГ монголиа билдинг ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 09-00-02/003/02 дугаартай 8 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн 09-00/08 дугаартай удирдамжаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн. Илэрсэн зөрчлийг 87 хувь арилгуулсан.<br>2. Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд харилцаа холбооны дэд бүтцийн байгууламжийн зураг төсөл, угсралтын байдалд Төрийн нарийн бичгийн даргын А/124 дугаар тушаалын дагуу 2024 оны 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 05-ны өдрүүдэд томилолтоор ажиллаж Ховд аймгийн Алтай сумын 1 дүгээр баг Бодонч, Мөнххайрхан сумын 2 дугаар баг Борт, 3 дугаар баг Хаг, Дуут сумын 3 дугаар баг Цагаан бургас, Мөст сумын 3 дугаар баг Баянхайрхан, Булган сумын 2 дугаар баг Баянсудал зэрэг газарт баригдах үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, 20 метр өндөр холбооны | 2024.02.06 - 2024.07.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цамхгийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийх талаар нийт 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгч, зөрчлийг 100 хувь арилгуулан ажилласан. | | |
| 4 | **Арга хэмжээ 2.2.5.** Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловруулж батлуулах | Батлуулсан удирдамжийн тоо | 3 | 3 | 1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Барилга, хот байгуулалтын яамны хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09-00/01,02-00/14 дугаартай урьдчлан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай.<br>2. 2024 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 09-00/05 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай.<br>3. 2024 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн 09-00/08 дугаартай гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх тухай.<br>4. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 420 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөг үндэслэн 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 09-00/13 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | 2024.01.02<br>-<br>2024.12.30 | 100 |
| 5 | **Арга хэмжээ 2.2.7.** Удирдлагаас өгсөн үүрэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ | 94.7 | 100 | 1. “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-иас ирүүлсэн албан бичгийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Сноу филдс ХХК-ийн СХД-ийн 20 хороонд баригдаж буй үйлдвэрийн барилын сууринд харилцаа холбооны шугам сүлжээ орсонтой холбоотой хяналт шалгалтыг хийж, харилцаа холбооны шугам сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах, шинээр хийх худаг сувагчлалын угсралтын ажлыг техникийн нөхцөл, зураг төслийн дагуу стандарт, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэх талаар Сноу филдс ХХК-д 09-00-02/001/01 дугаартай 2 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн.<br>2. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний 2024 оны 10 сарын 14-ний өдрийн 03/834 дугаартай албан | 2024.01.02<br>-<br>2024.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгээр ирүүлсэн гомдлын дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан 09-00/15 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу Монгол зам групп ХХК-ний дээр ажилласан. 2025 онд ажил эхлэхэд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний шилэн кабелийн трасс гүүрийн байгууламж болон замын 2 талаар шудуу ухахад замын трасст олон газраар давцаж байгаа тул зураг дээр ажиллаж шийдвэр боловсруулах талаар 09-00-02/003/07 дугаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Мөн Монгол зам групп ХХК-иас зүгээс төлөгдөөгүй байсан 2023, 2024 онуудад тасалсан шилэн кабелийг залгахад гардсан зардлыг бүрэн барагдуулж ажилласан. | | - |
| 6 | **Арга хэмжээ 2.2.8.** Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах, Улсын байцаагчийн шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг шалгах | Зөрчил арилгуулалтын хувь | 71 | 78 | 1. Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн 1/260 дугаар албан бичгийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн судалгааг гаргаж niislelprozurchil@gmail.com цахим шуудангийн хаягаар хүргүүсэн.<br>2. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 08/1584 тоот албан бичгээр Супервижн медиа групп ХХК-ийн SBN телевиз нь эд мөнгөний хонжворт сугалаатай холбоотой нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.13 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 51 дүгээр тогтоолоор баталсан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-ын 3 дугаар зүйлийн 3.21 дэх заалтыг зөрчсөн тул Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1дэх хэсгийн 1.1 дэх заалтын дагуу Зөрчлийн хэрэг үүсгэн 500 нэгжээр торгох арга хэмжээ авсан.<br>3. Нийслэлийн прокурорын газраас 2023, 2024 онуудад Мэдээлэл, харилцаа холбооны салбарын улсын байцаагчдийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан хэргийн материалд нэгдсэн үзлэг, шалгалт хийгдэж байгаатай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 25-нд хүлээлгэн өгч, | 2024.01.02 - 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | - | нийслэлийн прокурорын газрын шалгалтад хамруулсан. | | |
| **ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1.** Албан хаагчдын худалдан авах ажиллагаанд санал боловсруулж, ТЗУГ-т хүргүүлэх. | Худалдан авах ажиллагааны тоо | 1 | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Салбарын хяналтын газраас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний саналыг боловсруулж Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.<br>1. Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагчдын сургалт зохион байгуулах санал хүргүүлсэн. | 2024.01.02 - 2024.01.20 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 3.2.** Төрийн албаны зөвлөл, байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | 0 | 14 | Төрийн албаны зөвлөл мөн байгууллагаас зохион байгуулсан танхим болон цахим сургалтад нийт 15 удаа хамрагдаж хувь хүний хөгжил, төрийн албаны хууль эрх зүй болон мэргэжлийн мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | 2024.01.02 - 2024.12.30 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 3.3.** Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах | ХАСХОМ-ын тайлагналт | 1 | 1 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан. | 2024.01.02 - 2024.02.28 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 3.4.** Байгууллагын цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг | Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/ | 100 | 100 | 1. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид болон сайтуудын дунд зохион байгуулсан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой сургалтад оролцож, | 2024.01.02 - 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | | | | оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажилласан.<br>2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/18 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг ЦХХХЯ/202201001 “Мэдээлэл холбооны Дархан дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/” төсөлд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” А/40 дугаар тушаал, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Барилга, хот байгуулалтын яамны 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09-00/01, 02-00/14 дугаар удирдамжийн дагуу Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга, Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын ахлах байцаагч, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч, Барилга байгууламжийн техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн хамтарсан дүгнэлт, албан шаардлага, холбогдох мэдээлэлтэй танилцаж, хяналт шалгалтын үеэр илэрсэн зөрчил, доголдлыг гүйцэтгэгч талаас заасан хугацаанд арилгах боломжтой гэж үзэж, ажлын хэсгээс зөвлөмжийг хүргүүлсэн<br>3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаалаар Сансрын холбооны Кей Юү (KU) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, тайланг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Сайдад танилцуулсан. | | |
| 5 | **Арга хэмжээ 3.5.** Салбарын хяналтын газрын хөтлөх хэргийн | Хүлээлгэн өгсөн архивын нэгж | 50 | 100 | 2023 оны хяналт шалгалтын холбогдох баримт бичгийг 3 боть архивын нэгж болгон байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгсөн. | 2024.01.02<br>-<br>2024.04.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэрийн жагсаалтыг ТЗУГ-т хүргүүлэх, баримт бичгийг байгууллагын архивт хүлээлгэн өгөх | | | | | | |
| 6 | **Арга хэмжээ 3.6.** Олон улсын байгууллага, гадаад орнуудын ижил тестэй байгууллагатай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх | Хамтран ажиллаж буй байгууллагын тоо | 1 | 1 | 2024 оны сүүлийн хагаст Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран “5G Evolution: A Considerations of Technology, Spectrum Management, Licensing and Security Implications in the enclosure” сэдэвт Малайз улсад, “ITU Subregional workshop for Asia on promoting and measuring Universal and Meaningful Connectivity (UMC)” сэдэвт Тайланд улсад болох сургалт, хуралд зохион байгуулагч талын тэтгэлэгээр оролцох хүсэлт илгээсэн боловч татгалзсан хариу ирүүлсэн | 2024.07.01 - 2024.12.31 | 30 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | | | | | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ №1.<br>Мэргэжлийн зэргийг дээшлүүлэх зорилгоор магистарт дэвшин суралцах | Амжилттай суралцсан кредит цаг | 0 | 10 багц цаг | ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн магисртын сургалтад бүртгүүлж, төлбөрөө төлж баталгаажуулсан. | 2024.01.02 - 2024.06.30 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ №2.<br>Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад суралцах | Амжилттай суралцсан кредит цаг | 0 | 6 багц цаг | Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад суралцаж төгссөн | 2024.09.02 - 2024.12.13 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — С.ШИНЭБАЯР / .......................... / — 2024.12.06

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*